



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/28

Хэрлэн сум

Шагнаж, хөрөнгө зарцуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн гуравдугаар хавсралтын дагуу 2022 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр 1, 2, 3 дугаар байр эзэлсэн сумдын Засаг даргын Тамгын газрыг урамшуулахад зориулж, 3,930,000 (гурван сая есөн зуун гучин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3.1 дүгээр байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 80%, 2 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 60%, 3 дугаар байр эзэлсэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшуулал тус тус олгосугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.НОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны ... дүгээр сарын ...-ны дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Дадал	1	1.000.000	1.000.000
2	Бор-Өндөр	1	800.000	800.000
3	Өмнөдэлгэр	1	600.000	600.000
4	Батламж	3	30.000	90.000
5	Сургалтын заалны түрээс	-	300.000	300.000
6	Сургалтын цайны завсарлага	30	16900*2	1.014.000
7	Ус	30	1800*70	126.000
Дүн				3.930.000